



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/128

Батноров сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын (Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам)-ын 3.6.12 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 16 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1 Батноров сумын нутаг Баян 3 дугаар багийн нутаг Зүүн харз усны эх, Баруун харзны эхийг хашаалж, сэргээн засварлах зардалд 14000000 (Арван дөрвөн сая) төгрөгийг олгосугай.
- 2 Булаг шандын эхийг хашиж хамгаалах зардалд 14000000 (Арван дөрвөн сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү албаны Нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д үүрэг болгосугай.
- 3 Булаг шандын эхийг хашиж, хамгаалах ажлыг чанартай зохион байгуулахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Б.Өсөхбаяр)-д даалгасугай.



Б.ЖАВХЛАНБАЯР

236423291